Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тендерийн нэр: Биокомбинат ТӨААТҮГ-ын үйлдвэрлэлд ашиглах Давхар ус нэрэгчийн аппарат нийлүүлэх худалдан авах

Тендерийн дугаар: **БИО/201700038**

Биологийн үйлдвэрлэлд ашиглагдах давхар ус нэрэгч аппарат нь дараахь шаардлага хангасан байна. Үүнд:

1. Давхар ус нэрэгч аппарат нь биологийн үйлдвэрлэлийн GMP, FDA, ISO шаардлага, захиалагчийн техникийн үзүүлэлтэд нийцсэн байна.

2. Давхар ус нэрэгч аппарат нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.Олон Улсын стандартын шаардлага хангасан байна.

3. Давхар ус нэрэгч аппарат нь Биокомбинат ТӨААТҮГ-ын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн горим ажиллагаа, техникийн үзүүлэлттэй нийцсэн байх бөгөөд олон улсын стандарт шаардлага хангасан, тоо ширхэг бүрэн, урд нь ашиглагдаагүй, шинэ байна.

4. Давхар ус нэрэгч аппарат нь үйлдвэрлэгчийн дагалдах сертификат, чанарын гэрчилгээ, гарал үүслийг нотлох баримт, хаяг шошготой байна.

5. Давхар ус нэрэгч аппаратыг Биокомбинат ТӨААТҮГ-н Вирус-биобэлдмэл үйлдвэрлэлийн цехэд ашиглалтын зааврын дагуу эвдрэл, гэмтэлгүй тээвэрлэн, туслах эд ангийн хамт бүрэн бүтэн суурилуулж захиалагчид хүлээлгэн өгнө

6. Давхар ус нэрэгч аппарат нь биотехнологи, малын эмийн үйлдвэрлэл, лабораторид шаардлагатай цэвэрлэгдсэн ус бэлтгэх зориулалтаар ашиглах тул биологийн үйлдвэрлэлийн шаардлагад нийцсэн үзүүлэлттэй, бүрэн автомат ажиллагаатай, түүхий усны химийн элементүүдийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэршүүлэх технологитой, усны чанар нь биологийн үйлдвэрлэлийн шаардлагад нийцсэн байна

7. Давхар ус нэрэгч аппаратыг зааврын дагуу ашиглах талаар нийлүүлэгчээс сургалт зохион байгуулна. Сургалт зохион байгуулах зардал үнийн саналд багтсан байна

8. Дагалдах сэлбэгийг төхөөрөмжтэй хамт нийлүүлэхээс гадна түргэн элэгдэх сэлбэгийн жагсаалтыг гаргаж ирүүлнэ. Төхөөрөмжийн дэлгэрэнгүй /угсралтын/ схем зураг дагалдуулна.

9. Тоног төхөөрөмжийн дагалдах гарын авлага ном товхимлыг Англи, Монгол хэл рүү орчуулан хөрвүүлсэн байна

10. Давхар ус нэрэгч аппаратыг хамт хурдан элэгдэх сэлбэг хэрэгсэл дагалдуулна

11. Нийлүүлсэн төхөөрөмжинд 24-36 сараас дээш засварын баталгаа гаргана

12. Давхар ус нэрэгч аппарат нь биологийн үйлдвэрлэлийн шаардлагад нийцсэн, техникийн үзүүлэлт тохирсон, автомат ажиллагаатай, шинэ, ашиглагдаагүй байна

13. Нийлүүлэх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш 2 сар буюу 60 хоног байна

Давхар ус нэрэгчийн техникийн тодорхойлолт
1 ширхэг

Д/Д	Нэрс	Техникийн үзүүлэлт
1	Хүчин чадал	4-6 литр /цаг
2	Тень	Металл болон цахиур шилэн
3	Хүчин чадал /тень/	3 квт-аас доошгүй
4	Удирдлага	Дижитал
5	Resistivity megohm cm	0.4-0.6
6	Conductivity	<1.5
7	PH	5.5-6.5
8	Temperature	$<35^0C$
9	Min.supply pressure	5-6 psi
10	Fuse	13-15 amps
11	Power	220/240V